

**“ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 04 сарын 29

№ 24 / 01

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04-р сарын 29-ний өдрийн 14.00 цагт УБ хот Чингэлтэй дүүрэг 2-р хороо Центrpойнт төв “Бурхан халдун групп” ХХК-ийн хурлын зааланд болов.

Хуралд:

“Дархан зочид буудал” ХК нь 8.945 300 ширхэг хувьцаатайгаас хуралд хувьцаа эзэмшигч:

- 1. Намсрай овогтой Мөнхдаш- 7.109 300 ширхэг хувьцааны саналаар**
- 2. Би Ди Сек ХК – 1.314 590 ширхэг хувьцааны саналаар тус тус оролцов.**

Хурал зохион байгуулах комисс хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийж компанийн нийт гаргасан **8.945 300 хувьцааны** саналын эрхтэй хувьцааны тоог **8.423 890** ширхэг хувьцаагаар тогтоож хурлын ирц **94.1 %** тай байгааг мэдээлж компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлэхийг тооллогын комисс зөвшөөрөв.

Хурал 14 цаг 10 минутад эхлэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга С.Дагиймаа хурал эхэлсэнийг мэдэгдэв.

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд та бүхэнтэй нээлттэй ярилцаж санал бодлоо хуваалцахын зэрэгцээ өнгөрсөн жилд хийсэн ажлын бүтээмж, үйл ажиллагааны болон санхүүгийн талаар дүгнэж санал бодлоо илэрхийлэх боломж олдож байгаад баяртай байна.Цаашид компанийхаа төлөө тавьсан зорилго зорилтоо хэрэгжүүлж ажиллах үүднээс хамтарч ажиллах, компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх алдагдалыг бууруулах тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй байгааг нийт хуралд оролцож буй компаний эрх бүхий албан тушаалтнуудад өөрийн зүгээс байр сууриа илэрхийлэв. Ингээд хурал нээсэнийг мэдэгдэж хурлын дэгийг уншиж танилцуулъя.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

- Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг хэлэлцэж танилцуулах
- 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах
- ТУЗ-ийн гишүүдийг томилох.

Тус компанийн 2023 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулах талаар төлөвлөөд байна.

СОНССОН НЬ:

✓ **ТУЗ-ийн дарга П.Алимаа :**

Хурлын хэлэлцэх асуудлын дагуу 2023 онд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайланг танилцуулхад:

- **Үйлчилгээний соёл, стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр:**
 1. Сар бүрийн 2.4-р долоо хоногт ажлын байрны үзлэг хяналтыг хийж зөрчил дутагдалыг засаж ажилласан.
 2. Тоног төхөөрөмж болон зочид буудлын эд хогшилыг бүхэлд нь шинэчилсэн.
 3. Дархан зочид буудлын рестораны хөгжим техник, гэрэл гэрэлтүүлэг шинэчлэх ажил хийгдсэн.
 4. 2023.02.01-2023.10.01-ны хооронд Дархан төмөрлөгийн үйлдвэрийн 1800 ажилтны хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг П.Алимаа өөрийн катерингийн тусдаа багаар “Дархан зочид буудал ХК-ийн нэрийн дор үйлчилгээ үзүүлэн” хийсэн бөгөөд энэхүү ажил үйлчилгээнээс орж ирсэн ашиг орлогоос зочид буудлын дотоод засварын ажлыг 70%-тай хийж гүйцэтгэсэн.
 5. Зочид буудлын хангамжийн материал болон эд хогшилыг бүрэн шинэчилсэн.
 6. Барилгын бүх давхаруудыг бүхэлд нь чанарын шаардлага хангасан камераар бүрэн тоноглогсон.
- **Ашиг орлогоо нэмэгдүүлэх менежментийн чиглэлээр:**
 1. Өөрийн нэрийн бууз банш үйлдвэрлэх цех байгуулан борлуулалт хийж эхэлсэн.
- ТУЗ-ийн дарга П.Алимаагийн санаачлага, хөрөнгө түүний катеринг үйлчилгээний баг хамт олон 2023.02.01-ний өдрөөс Дархан төмөрлөгийн үйлдвэр ТӨХК ийн ажилчдын хоол үйлчилгээг хийх катеринг үйлчилгээ үзүүлэх гэрээг 3 сарын хугацаатай байгуулан 7 сарын хугацаанд ажиллаж энэхүү үйлчилгээнээс олсон ашиг орлогоос” Дархан зочид буудал” ХК ийн дотоод засвар тохижилтын ажлыг бүхэлд нь хийсэн.
- **Бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын чиглэлээр:**
 1. Ая дууны өргөө, караоке баар нийтийн танхим, VIP өрөөний бүх хэрэгсэлийг шинээр тохижуулсан.
 2. Зочид буудал хангамжийн хэрэгсэл шинэчилсэн.

3. Зочид буудлын 1,2,3 –р давхаруудын сантехникийн шугамуудыг иж бүрэн засварлаж шинэчилсэн.
4. Өдрийн хоолны хямдралтай үнийн 2 төрлийн багцийн хоолны цэс гарган үйлчилгээ үзүүлсэн.
5. Дотоод хяналтын чиглэлээр батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг бүрэн засуулж, дотоод хяналт шалгалтын тайланг аймгийн МХГазарт хугацаанд нь хүргүүлж ажилласан.
6. Зочид буудлын барилгын А.Б блокт урсгал засвар, тохижилт хийж бүрэн тохижуулсан.

✓ **Хувьцаа эзэмшигч Н.Мөнхдаш:**

Өөрийн хөрөнгөөр 2014 оноос хойш тасралтгүй хөрөнгө оруулж ирсэн бөгөөд Дархан зочид буудалд 400 000 000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийж зочид буудлын дотоод засалд, лоунж, гадна терасыг иж бүрэн тохижуулсан.

Би Ди Сек”ХК –ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч М.Баяр-Өлзий :

Бидний зүгээс дэмжиж хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна. Өнөөдрийн хурлаас гарч байгаа бүх шийдвэрүүдийг дэмжиж байна.

✓ **ТУЗ-ийн дарга П.Алимаа :**

2024 онд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд:

Үйл ажиллагааны чиглэлээр:

- Аймаг орон нутгийнхаа БОАЖГ-аас зохион байгуулагдаж буй үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдаж оролцох , аялал жуулчлалыг дэмжих жилийн хүрээнд бизнес төлөвлөгөө гаргаж ажиллах, хөрш зэргэлдээ орнуудын үзэсгэлэнд оролцож туршлага судлах
- Цаашид бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ орлого нэмэгдүүлэх тал дээр ихээхэн анхаарч ажиллана.

Баг хамт олны олон нийтийн үйл ажиллагаа

- Ажилчдын хөдөлмөр хамгаалалын ажлын дүрэмт хувцсыг олгох
- Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд ажилчдыг бүрэн хамруулах
- Халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлж ажилчдадаа витаминжуулалт хийх
- Үйлчилгээний стандарт харилцаа хандлагын талаарх сэдэвчилсэн төрөл бүрийн сургалтыг зохион байгуулах

Санхүү мэдээ борлуулалт

- Санхүү нийгмийн даатгалын, татварын тайлангуудыг цаг хугацаанд нь гаргаж хүргүүлэх

- Бараа материал түүхий эдийн үнийн судалгаа гаргаж хямд чанартай бараа бүтээгдэхүүнээр хангах
- Байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллана.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай хэмээн үзсүгэй.
2. “ ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ” ХК нь 2023 онд 929.260.925.33 төгрөгийн ашигтай ажилласан боловч компани нь зочид буудлын барилгад их засвар хийж, санхүүгийн тайланд тусгагдсан хуримтлагдсан өр төлбөр их байгаа тул өр төлбөрөөс барагдуулсан тул ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтоосон ТУЗ-ийн шийдвэрийг баталсугай.
3. 2024 онд бизнесийн үйл ажиллагааг эрчимжүүлж, ашигтай ажиллах талаар идэвх санаачлага гарган ажиллахыг Гүйцэтгэх захирал Э.Алтанзул-д даалгасугай.

Хурал хэсэг засварласаны дараа тооллогын комисс саналын хуудасыг тоолж тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Хурал 16.30 –д өндөрлөв.

Хурал удирдсан хурлын дарга: / П.Алимаа /

Протокол бичсэн: / С.Дагиймаа /

